

ДОТООД АУДИТЫН ГАЗРААС
МОНГОЛБАНКНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
АУДИТЫН ДҮГНЭЛТ

Дотоод аудитын газраас 2014 оны А-115 дугаар тушаалаар батлагдсан "Монголбанкны Дотоод хяналт шалгалтын дүрэм", "Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааны ерөнхий заавар", "Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газрын хянан шалгагчийн гарын авлага", Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу Монголбанкны худалдан авах ажиллагаанд аудит шалгалт хийлээ.

Аудитын зорилго: Монголбанкны худалдан авах ажиллагаа нь хууль тогтоомж, Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан холбогдох журам, заавар, шийдвэртэй нийцэж буй эсэхэд дүгнэлт өгөх.

Аудит хамрах хугацаа: 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаа.

Аудит хийх хугацаа: 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл.

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, шийдвэр гаргалт.

Монголбанкны хэмжээнд бараа, ажил, худалдан авах хэрэгцээ шаардлагыг нэгжүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн тогтоох, төсөв төлөвлөгөө зохион батлуулах, худалдан авалтыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль", "Монголбанкны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам"-ын дагуу явуулах, үнэлгээний хороо байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг Тамгын газар (цаашид ТГ гэх) хариуцан хэрэгжүүлж байна.

ТГ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль", "Монголбанкны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам"-д заасны дагуу үнийн дүнгээс хамаарч дараах аргуудаар худалдан авалтыг хийж ашиглаж байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын арга,
- Үнийн санал авах буюу харьцуулалтын арга,
- Шууд худалдан авалтын арга.

1. Нээлттэй тендэр шалгаруулалтын аргаар хийсэн худалдан авалт.

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль", "Монголбанкны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам"-ын дагуу нээлттэй тендэр шалгаруулалтын аргаар худалдан авалт хийх үнийн босгын болзол хангасан нийт 10 тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгч тушаал гаргаж үнэлгээний хороо байгуулан, нээлттэй тендэр зарлаж, худалдан авалт хийсэн байна. Үүнд:

Монголбанкны Архангай аймаг дахь Монголбанкны салбарын барилга барих.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А-007 дугаар тушаалаар Архангай аймаг дахь Монголбанкны салбарын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан байна.

Архангай аймаг дахь Монголбанкны салбарын барилгыг барих ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооний зүгээс тендер сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажилласан байна гэж дүгнэсэн.

Монголбанкны “Б” байрны дээврийг шинэчлэх.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А-66 дугаар тушаалаар Монголбанкны “Б” байрны дээврийг шинэчлэх ажлыг гүйцэтгэх эрх бүхий этгээдийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан байна.

Монголбанкны “Б” байрны дээврийг шинэчлэх ажлыг гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооний зүгээс тендер сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж ажилласан байна гэж дүгнэсэн.

Монголбанкинд үнэт металлын сорьц тогтоох лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А-110 дугаар тушаалаар Дархан-Уул, Баянхонгор аймгийн төвд алт худалдан авалтын нэг цэгийн үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан шаардалагтай тоног, төхөөрөмж худалдан авах үйл ажиллагааг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан байна.

Монголбанкинд Шинжилгээний алт хайлуулах зуух, Аналатик жин, жингийн ширээ, эталон туухайны хамт тус тус худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооний зүгээс тендер сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж ажилласан байна гэж дүгнэсэн.

Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбаруудад агааржуулагч /эйр кондишн/ нийлүүлэх.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А-56 дугаар тушаалаар Монголбанкны орон нутаг дахь хэлтэс (салбар)-ын сервер, тоног төхөөрөмжийг хөргөх зориулалтаар эйр кондишн худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан байна.

Монголбанкны ажлын хэрэгцээнд зориулан эйр кондишн худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооний зүгээс тендер сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж ажилласан байна гэж дүгнэсэн.

Монголбанкинд компьютер нийлүүлэх

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А-009 дүгээр тушаалаар Монголбанкны албан хэрэгцээнд зориулан компьютер худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан байна.

Монголбанкны ажлын хэрэгцээнд зориулан компьютер худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооний зүгээс тендер сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж ажилласан байна гэж дүгнэсэн.

Монголбанкны ажлын хэрэгцээнд зориулан сервер, сүлжээний тоног төхөөрөмж худалдан авах.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А-52 дугаар тушаалаар батлагдсан Монголбанкны ажлын хэрэгцээнд зориулан сервер, сүлжээний тоног

төхөөрөмж худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан байна.

Монголбанкны ажлын хэрэгцээнд зориулан сервер, сүлжээний тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооний зүгээс тендер сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж ажилласан байна гэж дүгнэсэн.

Монголбанкинд автомашин нийлүүлэх

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А-11 дүгээр тушаалаар батлагдсан Монголбанкны орон нутаг дахь хэлтэс (салбар)-ын албан хэрэгцээнд автомашин худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан байна.

Монголбанкны орон нутаг дахь хэлтэс (салбар)-ын албан хэрэгцээнд автомашин худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооний зүгээс тендер сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж ажилласан байна гэж дүгнэсэн.

Монголбанкинд тог баригч, дизель генератор худалдан авах

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А-44 дүгээр тушаалаар батлагдсан Монголбанкны цахилгааны тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангахад зориулж тог баригч, дизель генератор худалдан авах үйл ажиллагааг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан байна.

Тог баригч, дизель генератор худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хорооний зүгээс тендер сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж ажилласан байна гэж дүгнэсэн.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн А-127 дугаар тушаалаар батлагдсан Монголбанкны үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан байна.

Монголбанкны үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг үргэлжилж байгаа тул дүгнэх боломжгүй байна.

Монголбанкнаас хэрэгжүүлсэн төсвийн шинжтэй хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн тусгай үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А-51 дүгээр тушаалаар батлагдсан Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр” болон үүнтэй адилтгах бусад санхүүжилтийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн тусгай үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан байна.

Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр” болон үүнтэй адилтгах бусад санхүүжилтийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн тусгай үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг

сонгохдоо зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын хосолсон үнэлгээний аргаар зохион байгуулсан байна.

Аудит хамрах хугацаанд Монголбанк бараа, ажил үйлчилгээг нээлттэй тендэрийн аргаар худалдан авсан дээрх 10 тохиолдол тухай бүр Монголбанкны цахим хуудас, “Өнөөдөр”, “Өдрийн сонин”-оор дамжуулан нийтэд мэдээлж ажилласан байна. Мөн тендэрийн үнэлгээний хороод нь тендэр зарлах, шалгаруулах, гэрээ байгуулах зэрэг худалдан авалттай холбоотой бүх үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.2, 8.2 дахь заалт, “Нээлттэй тендер шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулж ажиллажээ.

2. Үнийн санал авах буюу харьцуулалтын аргаар хийсэн худалдан авалт:

Харьцуулалтын аргыг тухайн бараа, ажил үйлчилгээг нийлүүлэх, гүйцэтгэх туршлага бүхий этгээдүүдээс үнийн санал авч, “Монголбанкны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам”-ын дагуу сонголт хийж, удирдлагад танилцуулан, гэрээ байгуулах хэлбэрээр хэрэгжүүлсэн байна.

Гэрээтэй холбоотой материалд холбогдох компанийн санал, чанар, үнэ, нийлүүлэх хугацаа, баталгаат хугацаа, туршлага болон бусад нөхцөл шалгуурыг харьцуулан судалсан танилцуулгыг хавсаргасан байна.

3. Шууд худалдан авалтын аргаар хийсэн худалдан авалт:

Монголбанкны шууд болон харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагаа нь хууль журмын дагуу зохион байгуулагдсан боловч худалдан авалт хийх аргуудыг журмын дагуу сонгоогүй тохиолдлууд илэрсэн болно.

ДОТООД АУДИТЫН ГАЗАР